


ТАНИЛЦУУЛГА

Нэг. 2015 онд Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2015 онд иргэд, байгууллагаас 9554 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 195 нэгж буюу 2.4 хувиар өссөн байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 381 буюу 4.0 хувь нь санал, 8989 буюу 94.1 хувь нь өргөдөл, 184 буюу 1.9 хувь нь гомдол байна.



Санал, өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 1367 буюу 14.3 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 336 буюу 3.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1772 буюу 18.5 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2542 буюу 26.6 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 456 буюу 4.8 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 3081 буюу 32.2 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 9522 буюу 99.6 хувийг шийдвэрлэж, 32 буюу 0.4 хувийн өргөдлийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2015 онд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 728 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 142 нэгж буюу 16.3 хувиар буурсан байна.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 40 буюу 5.5 хувь нь санал, 858 буюу 91.8 хувь нь өргөдөл, 20 буюу 2.7 хувь нь гомдол байна.




Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 87 буюу 12.0 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 36 буюу 4.9 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 169 буюу 23.2 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 214 буюу 29.4 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 32 буюу 4.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 190 буюу 26.1 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төв ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар

2015 онд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 328 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 158 буюу 48.2 хувь нь санал хүсэлт, 128 буюу 39.2 хувь нь гомдол, 22 буюу 6.7 хувь нь талархал, 17 буюу 5.2 хувь нь шүүмжлэл, 3 буюу 0.9 хувь нь өргөдөл байна.




Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 294 буюу 89.6 хувийг шийдвэрлэж, 34 буюу 10.4 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 216 буюу 66.5 хувийг 5 хоногийн дотор, 75 буюу 23.1 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2015 онд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 1825 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 265 нэгж буюу 16.9 хувиар өсч, 1959 алба хаагч холбогдсоны 1411 буюу 72.0 хувь нь офицер, 533 буюу 27.2 хувь нь ахлагч, 15 буюу 0.8 хувь нь энгийн бүрэлдэхүүн байна. Нийт өргөдөл гомдлын 1772 буюу 97.1 хувийг барагдуулж, 53 буюу 2.9 хувийн үлдэгдэлтэй байна.



ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС